

А

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШ Ү
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулах, төсвийн төслийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохицуулахад бүх талын	-	-	-	-	-	Монгол улсын “Төсвийн тухай” хуулийн 8.9.1 дүгээр зүйл, “Нягтлан бодох бүртгэл”-ийн тухай хууль болон бусад холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах аргачлал, Эдийн засаг, хөгжлийн яамны нягтлан бодох	100%	100%

	дэмжлэг үзүүлэх, ерөнхийлөн захирагчийн болон яамны аппаратын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;						бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/-ийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, авлага, өглөг, бараа материал, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн тайлангуудын тохируулга, аккруэл суурьт шалгах балансыг хийж 2025 оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид тус тус хүргүүлж тайлагнав.		
3.1.1	Байгууллагын санхүү, төсвийн асуудлыг эрхлэн гүйцэтгэж, өдөр	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц, хувиар	2024 оны байдлаар гадаад, дотоодын байгууллагуудтай байнгын хамтын	Байгууллагын дотоод үйл ажиллагааг 100 хувьд хүргэнэ. /Дээшлүүлсэн хувь -100 хувь/	Байгууллагын дотоод үйл ажиллагааг 100 хувьд хүргэнэ. /Дээшлүүлсэн хувь -100 хувь/	Монгол улсын "Төсвийн тухай" хуулийн 8.9.1 дүгээр зүйл, "Нягтлан бодох бүртгэл"-ийн тухай хууль болон бусад холбогдох хууль, Улсын секторын	100%	100%

	<p>тутмын хэвийн үйл ажиллагааг явуулна.</p>			<p>ажиллагаатай ажиллаж байна.</p>			<p>нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах аргачлал, Эдийн засаг, хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/-ийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, авлага, өглөг, бараа материал, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн тайлангуудын тохируулга, аккурэл суурьт шалгах балансыг хийж 2025 оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах</p>		
--	--	--	--	------------------------------------	--	--	---	--	--

20

							дээд шатны төсвийн захирагчид тус тус хүргүүлж тайлагнав.		
3.1 .2	Яамны албан хаагчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг тайлагнана.	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн хувь	Цалин олголт, НДШ, татварын тайлан тухай бүр гаргаж тайлагнасан.	Цалин олголт, НДШ тайлан, татвар тайлан гаргасан хувь	Цалин олголт, НДШ тайлан, татвар тайлан гаргасан хувь	Яамны албан хаагчдын цалин бодолт, нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ын тайланд хяналт тавьж холбогдох тооцооны нягтлан бодогчид ажил үүргийн чиглэл өгч ажилласан. ЭЗХЯ нь энэ оны 5 сарын 31-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийтдээ 117 албан хаагчдад 2,052.2 сая төгрөгийн цалин хөлс болон бусад нэмэгдлийг тооцож бодсоноос, Нийгмийн даатгалд 134 албан хаагчийн 495.5 сая төгрөгийн ХХОАТ-176.7 сая төгрөг тус тус тооцож хуулийн хугацаанд нь тайлагнасан байна. ЭЗХЯ нь сар бүр албан хаагчдын ажлын цагийн тооцооллыг ер-mongolia системээс бодит байдлаар хүн нэг бүрчлэн тулгалт хийж бүртгэн цалин бодсон бөгөөд ажлын ирцтэй холбоотой асуудлуудыг ажилтан бүртэй холбогдож тодруулан уг	100%	100%

							системийг мөрдөн ажиллах зааварчилгаа өгч цалингийн мэдээллийг албан хаагчдад мэйлээр хүргүүлсэн болно.		
3.1 .3	Байгууллагын шилэн дансны мэдээлэл оруулна.	Үйл ажиллагааны зардлаар	Шилэн дансны мэдээллийг хугацаанд оруулсан байх, хувиар	Тухай бүр мэдээлэл оруулсан.	Тайланг тухай бүр хугацаанд www.shiilendans.gov.mn сайтад байршуулна. /100 хувь/	Тайланг тухай бүр хугацаанд www.shiilendans.gov.mn сайтад байршуулна. /100 хувь/	Байгууллагын шилэн дансны мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн байгууллага гэсэн 2 ангиллаар ахлах нягтлан бодогчид хамаарагдах жил бүр-6, хагас жил-4, сар бүр-2, тухай бүр-5 хэсгийн мэдээллийг оруулахаас сар болон тухай бүрийн мэдээллийг цаг хугацаанд оруулсан болно. Тухай бүрдээ шилэн дансанд доорх байдлаар ил тод болгож оруулсан: 1. Сар бүрийн төсвийн хөтөлбөр, зориулалтаар батлагдсан төсөв гүйцэтгэл хэмнэлт хэтрэлтийн тайлан 2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн	100%	95%

							дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 4. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн Тухайн сард шилэн дансны мэдээллийн хугацаандаа мэдээлсэн болно. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 53 харилцагчийн 3,202.9 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг ил тод болгож илтгэсэн.		
3.1 .4	Газрын чиг үүрэг хамаарах худалдан авах ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардлаар	Худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан байх, хувиар	Худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.	Худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. /100 хувь/	Худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. /100 хувь/	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025 оны хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг А/21 дугаартай тушаалаар батлуулсан. Тушаалын дагуу Төрийн	100%	95 %

						<p>захиргааны удирдлагын газрын хариуцан хэрэгжүүлэх төлөвлөгөө нийт 1268.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг газрын даргаар батлуулан ажиллалаа. 06 дугаар сарын 05-ны байдлаар 15 төсөлд гэрээ хийгдэн, 11 төсөл гэрээ байгуулах шатанд судлагдаж, 5 төслийн хугацаа болоогүй байна. Яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 13 албан хаагчдыг АЗ сертификатын эрх олгох сургалтад зардлыг шийдвэрлэн оролцуулж, худалдан авах ажиллагаа зохион байгуулах газар, хэлтсийн мэргэжилтэнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Мөн газрын дотоод бичгээр 2 удаа чиглэлийг хүргүүлж, тайланг тухай бүрд газрын дарга, ТНБД-д танилцуулсан эрчимжүүлсэн. 2025</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							оны А/129 дугаартай тушаалын дагуу яамны худалдан авах ажиллагааг зохион байгуулахад оролцсон 8 үнэлгээний хорооны гишүүдэд нийт 3910.3 сая төгрөгийг цалингийн зардлаас, тендерийн баримт бичиг борлуулалтын орлогоос хараат бус гишүүдэд жигд хуваарилан урамшуулал олгохоор шийдвэрлэсэн. Яамны худалдан авах ажиллагааны үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны болон Шилэн данс цахимд тухай бүрд нийтэлж байна. Системд үнэлгээний хороог байгуулах, Тендер шалгаруулалтын баримт бичгийг баталгаажуулан тендер зарлах ажлыг зохион байгуулан ажиллалаа.		
3.1 .5	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн хүрээний	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц, хувиар	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл,	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын төслийн нэгтгээ	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын төслийн нэгтгээ	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын дарга нарт Төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн 2026 оны төсвийн төсөл, 2027-	100%	100%

27

	<p>мэдэгдэл, төсвийн хязгаарын төслийн саналыг нэгтгэн, боловсруулна.</p>			<p>төсвийн хязгаарын төслийг нэгтгэн боловсруулсан.</p>	<p>боловсруулсан байна. /100 хувь/</p>	<p>боловсруулсан байна. /100 хувь/</p>	<p>2028 онуудын төсөөллийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх тухай 01/1373 дугаартай албан бичгийг хүргүүлээд байна. Мөн яамны газар, хэлтсүүдэд 2026 оны төсвийн төсөл боловсруулахтай холбоотой зарим төлөвлөж буй ажлуудын хүрээнд гарах зарлагын тооцоог ирүүлэх тухай хугацаатай дотоод бичиг хүргүүлсэн. Төсвийн төслийн саналыг хуулийн хугацаанд хүргүүлэх бэлтгэл ажлуудыг хангасан. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулах хэлэлцүүлэг 03 дугаар сарын 20-ны өдөр тус яамнаас зохион байгуулж, иргэд олон нийтийн дунд санал асуулга явуулсан. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай төслийг</p>	
--	---	--	--	---	--	--	--	--

25

							Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Тэргүүн Шадар сайд Улсын Их Хуралд өргөн барьж батлуулаад байна. Хуулийн төслийг боловсруулахдаа дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, төсвийн алдагдал болон өрийн хэмжээг үе шаттайгаар бууруулах бодлогыг баримтлахаас гадна холбогдох хуулийн шаардлагад бүрэн нийцүүлэн төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангаж, холбогдох саналуудыг тусгасан.		
3.1 .6	Яамны хөрөнгийн тооллого хийнэ.	Үйл ажиллагааны зардлаар	Тооллого хийх тоо /тоо/	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Яамны хөрөнгийн тооллогыг хагас болон бүтэн жилээр тоолсон байна. / 2 тооллого/	Яамны хөрөнгийн тооллогыг хагас болон бүтэн жилээр тоолсон байна. / 2 тооллого/	Албаны хэрэгцээнд ашиглагддаг хөрөнгийн хөдөлгөөнд болон өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна. Яамны худалдан авалтыг оруулахдаа хөрөнгө, бараа материалын нэршил болон кодчиллыг нэг	100%	90 %

							хэв загвартайгаар боловсруулан бэлдэж хийсэн бөгөөд хагас жилийн үндсэн хөрөнгийн тооллогыг эхлүүлэн газар, хэлтэс, хүн тус бүрээр нь шинэчилсэн хөрөнгийн кодчилолтой тулгалт хийж нүдээр харж гараар барин тоолж тооцоо бодолт хийсэн. Тооллогоо тусгай наалттай цаасан дээр эзэмшигчийн нэр, барааны нэр, дүн бар кодтойгоор хэвлэж нааж баталгаажуулсан. Тооллогын үр дүнг өмч хамгаалах комиссын хуралд балансаас баланс луу шилжүүлэх, актлах хөрөнгө бараа материалыг жагсаалтаар танилцуулж ТӨМХБЗ-ыг газарт санал хүргүүлэхээр бэлтгэж байгаа болно.		
3.1 .7	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн тайланг нэгтгэн гаргана.	Үйл ажиллагааны зардлаар	Тайлангийн тоо /тоо/	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн тайланг нэгтгэн холбогдох байгууллагад	Тухай бүр хэрэгжүүлж ажилласан байна. /8 тайлан/	Тухай бүр хэрэгжүүлж ажилласан байна. /8 тайлан/	Монгол улсын "Төсвийн тухай" хуулийн 8.9.5 дүгээр зүйл, "Нягтлан бодох бүртгэл"-ийн тухай хууль болон бусад холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын	100%	100%

127

				хүргүүлсэн.		стандарт, Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах аргачлал, Эдийн засгийн хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу Монгол улсын Тэргүүн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган хөтөлж, жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж санхүүгийн этайлан системд хугацаанд шивсэн болно. Жилийн эцсийн санхүүгийн тайланг улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүн, улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн,и төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл баталгаа гаргах , арилжааны банкны дансны үлдэгдэл, ТЕЗ-ийн 2024		
--	--	--	--	-------------	--	---	--	--

							онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрсэн үр дүнгийн талаарх чанарын тоон үзүүлэлт, кассын зарлагын нэгтгэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгах, фрий баланс программын гүйцэтгэлтэй тулган шалгах, санхүүгийн тайлан шалгуулж Сангийн яамны төрийн сан, хөрөнгө оруулалтын хэлтэстэй тойрох хуудсаар тооцоо нийлсэн.		
3.1 .8	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг шуурхай	Үйл ажиллагааны зардлаар	Санхүүжилтийн явц, хувиар	-	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг олгосон байна. /100 хувь/	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг олгосон байна. /100 хувь/	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шинээр "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Бүсүүд/" 20.0 тэр бум төгрөг батлагдсан бөгөөд сайдын 2025 оны 01/689, 01/727 дугаартай нийт 14,689.1	100%	95 %

24


олгох арга хэмжээ авна.						сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт цахимаар шилжүүлсэн.Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу үлдэх 54 төслийн 26,414.08 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн харилцах дансанд төвлөрүүлсэн бөгөөд эхний 5 сарын 31-ний байдлаар 39 төслийн 6,818.3 сая төгрөг, "Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг, 13-р хороо/ "Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор" шилжих төсөлд 4,293.8 сая төгрөг, "Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төслийн шүүхийн шийдвэрийн дагуу хийгдэх эргэн төлөлт/Баянхонгор/ 10,983.5 сая, нийт 22,380.9 сая төгрөгийн санхүүжилт		
-------------------------------	--	--	--	--	--	--	--	--

						<p>олгосон.2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр хэрэгжүүлсэн бөгөөд сар бүр гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээг Сангийн яаманд хүргүүлж байна.</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

Үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн дарга

(албан тушаал)



(гарын үсэг)

/И.Батхүү/

2025.06.25

(огноо)

Тайлагнасан:

ТЗУГ-ын СХОХ-ын дарга

(албан тушаал)

A handwritten signature in black ink, appearing to read 'J. Gerelbat', is written over a dotted line.

(гарын үсэг)

/Ж.Гэрэлбат/

2025.06.25

(огноо)